Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн бие махбодын өөрчлөлтийн онцлогийг тодорхойлсон судалгаа

Х.Пүрэвжав[1], Ж.Энхцэцэг[1], З.Болортулга[1], А.Анхзаяа[2], Г.Эрдэнэчимэг[2]

[1]Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
[2]Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Уламжлалт эмчилгээний тасаг
Цахим хаяг: chimgee6707@gmail.com

Түлхүүр үг:
Бие махбодын өөрчлөл
Цэвэршилт
Бадган, шар хавсарсан махбод
Дан болон хурмал өөрчлөл

Товч утга: Эмэгтэй хүн 45-50 насны хооронд сарын хир алдагдан улмаар зогсох бөгөөд өндгөвчний үйл ажиллагаа нь аажим буурч цэвэршихийн өмнө хойно махбодын харьцангуй тэнцвэр алдагдаж хямралын шинж гардаг ирдэг. Тиймээс бид цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн махбодыг "Өвчнөөс сэргийлэх, оношлох үндсэн зарчмын логик арга зүйн судалгаа"-ны биеийн өөрчлөлийг тодорхойлох 4 шалгуур үзүүлэлт бүхий асуумжаар бөглүүлэхэд цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн бие махбодийн өөрчлөл хий дийлэнх махбодтой, бадган, шар хавсарсан махбодтой байна. Мөн дан болон хурмал хэлбэрийн өөрчлөлтэй хүн илрээгүй бөгөөд хий дийлэнх хавсарсан өөрчлөлтэй байсан.


Үндэслэл: "Алтан хадмал" зохиолд "махбодын мөн чанарын үүднээс ялгахад товчлон үзүүлэх болон дэлгэрэнгүй үзүүлэх хоёр бий. Биеийн өөрмөц талаас товчлон үзүүлэхэд хий, шар, бадган дан дангаар гурав, хий шар, бадган шар, бадган хий тус тус хавсарсан гурав, гурвуулаа хурсан нэгтэй нийлүүлээд 7 зүйл"[1]. "Хөх биндэръя"-д "хүний мөн чанарын 7 зүйлийг хооронд нь харьцуулбал ерөнхийдөө сүүл сүүлийнх нь сайн бөгөөд урьдах нь бүх талаараа бүрэн бус байдаг. Өөрөөр хэлбэл хавсарсан нь дангаасаа сайн, хурмал нь хавсарснаасаа сайн гэвч бүгдээрээ ийм хэмээн баталж чадахгүй"[2] гэж заасан байдаг. Бие махбодод нэг талаас халуун ба аргын мөн чанарыг илтгэсэн хүч болох шар, нөгөө талаас хүйтэн буюу билгийн мөн чанарыг илтгэсэн хүч болох бадган, халуун хүйтэн хоёрт хоёуланд нь түгэж орших чанартай хий гэсэн 3 махбод нь хоорондоо зохистой тэнцвэрт харьцаанд оршсоноор бие эрүүл байдаг. "Анагаах ухааны дөрвөн үндэс"[3] болон "Увдисын үндэсний тайлбар сайн номлолт алтан чимэг"[4] зохиолд "Хий бол өвчин бүхнийг хямралдуулан эхийг удирдах, сүүлийг хураах, тархаах, түгээн үйлдэж өөрийн үндсэнд хортой бөгөөд олон өвчнийг ширүүдүүлэхийн тул эн тэргүүнд хий өвчнийг зас" гэжээ. Иймээс аливаа өвчин эмгэгийн үед бие махбодийн өөрчлөлийг тогтоох нь чухал ач холбогдолтой байна.

Зорилго: Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн бие махбодын өөрчлөлийн онцлогийг тодорхойлсон судалгаа

Зорилт: Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн бие махбодын өөрчлөлийг тодорхойлох.

Хэрэглэгдэхүүн, арга аргачлал: Бид судалгаандаа 45-55 насны 21 эмэгтэйг хамруулан нэг агшны асуулга судалгаа хийж гүйцэтгэлээ. Б.Дагвацэрэн, Н.Төмөрбаатар, Ө.Батчимэг нарын "Өвчнөөс сэргийлэх, оношлох уламжлалт анагаах ухааны үндсэн зарчмын логик, арга зүйн судалгаа"-ны (2003) биеийн өөрчлөлийг тодорхойлох шалгуур (дэлгэрэнгүй хэлбэр), 4 шалгуур үзүүлэлт бүхий асуумж бөглүүлэн үр дүнг тооцон судалсан.


Үр дүн:



Зураг 1. Хий дийлэнх бадгана ба шарын тохиолдох хувийг насны ангиллаар ялгасан байдал


Судалгааны үр дүнд нийт эмэгтэйчүүдийн насны ангилалаар авч үзвэл 45-49 насны эмэгтэйчүүд

42.9%-ийг эзэлж байгаа ба 44.4% нь хий дийлэнх бадган хавсарсан өвөрчлөлтэй байна. Харин 50-55 насны эмэгтэйчүүд 57.1%-ийг эзэлж байгаа ба 33.3% нь хий дийлэнх шар хавсарсан өвөрчлөлтэй байна.



Зураг 2, Өвөрчлөлийн хэлбэрүүдийг (% оор илэрхийлсэн)

Мөн судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 28.7% нь хий дийлэнх бадган хавсарсан өвөрчлөлтэй, 19% нь бадган дийлэнх шар хавсарсан өвөрчлөлтэй, 19% нь шар дийлэнх хий хавсарсан өвөрчлөлтэй, 19% нь хий дийлэнх шар хавсарсан өвөрчлөлтэй, 9.5% нь шар дийлэнх бадган хавсарсан өвөрчлөлтэй, 4.8% нь бадган дийлэнх хий хавсарсан өвөрчлөлтэй байна.



Зураг 3, Цэвэршилтийн насны э мэгтэйчүүдийн бие махбодын өвөрчлөл (судас ба шээсээр илрэх нь)

Мөн цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн бие махбодын өвөрчлөл нь судас болон шээсний илрэлийн уялдаа хамааралын онцлог өөрчлөлтүүд буй эсэхийг судлах зорилгоор судсыг шинжлэхэд нийт эмэгтэйчүүдийн 25% нь хий шар хавсарсан судас өнгөц, нарийн, түргэн, дарахад зогсоно, 40% нь хий бадган хавсарсан судас гүн, урт, алгуур, нэмж дарахад зогсдог, 35% нь бадган шар хавсарсан судас удаан, гүн, бүдүүвтэр, дарахад тэсвэртэй өргөн байна.

Шээсийг шинжлэхэд нийт эмэгтэйчүүдийн 30% нь хий шар хавсарсан шээс өнгө нь хөхөвтөр, үнэр нь бага цөвийн үнэртэй, хөөс нь жижиг бөгөөд түргэн арилна, 20% нь хий бадган хавсарсан шээс өнгө нь цайвар, үнэр нь бага, цөвийн үнэртэй, язмаг нь савны ёроолд хялгас мэт нарийн, 30% нь бадган шар хавсарсан шээс өнгө нь өнгөгүй шахам, үнэр нь маш бага заваан үнэртэй, язмаг нь савны дунд хөвөн зулсан мэт зузаан, 5% нь хийн шээс өнгө нь хөхөвтөр, үнэр нь бага цөвийн үнэртэй, язмаг нь савны дээд хэсэгт үс бутарсан мэт, 10% нь шар хий хавсарсан шээс өнгө нь тод шар, үнэр нь өмхий, язмаг нь савны дээд хэсэг үс бутарсан мэт, 5% нь шар бадган хавсарсан шээс өнгө нь тод шар, үнэр нь заваан үнэртэй, язмаг нь савны дунд хөвөн зулсан мэт зузаан байна.

Хэлцэмж: Б.Дагвацэрэн, Н.Төмөрбаатар, Ө.Батчимэг нар "Өвчнөөс сэргийлэх, оношлох уламжлалт анагаах ухааны үндсэн зарчмын логик, арга зүйн судалгаа"-ы (2003) үр дүнд бие махбодын хяналт-удирдлагын код болох хий, шар, бадганы түвшинд (бие, хэл, сэтгэлийн үйлийн) үзүүлэх гадаад орчны нөлөөлөл (идээ ундаа, эм, засал г.м) нь эргэх холбооны боломжит бүх л хэлбэрээр хэрэгждэг бөгөөд өвчнийг сэргийлэх, оношлох 6 үндсэн зарчим мөрдөгддөг болох нь тогтоогдлоо. Эдгээр нь өвчнийг оношлох, сэргийлэх, эмчлэх нийтлэг үндэслэл болдог байна. Биеийн өвөрчлөлийг тодорхойлох аргачлалыг боловсруулж явуулсан судалгааны дүнгээс үзвэл дан ба хурмал хэлбэрийн өвөрчлөлтэй хүн илрээгүй бөгөөд хий шар хавсарч давамгайлсан хүн 57%, шар бадган хавсарч давамгайлсан 24%, үлдсэн 19% нь бадган хий хавсарч давамгайлсан өвөрчлөлтэй байсан.

Дүгнэлт: Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн бие махбодийн өвөрчлөл хий дийлэнх махбодтой, бадган, шар хавсарсан махбодтой байна.Биеийн өвөрчлөлийг тодорхойлох шалгуур үзүүлэлт бүхий асуумжаар авсан судалгааны дүнгээс үзэхэд дан болон хурмал хэлбэрийн өвөрчлөлтэй хүн илрээгүй бөгөөд хий дийлэнх хавсарсан өвөрчлөлтэй байсан.

Талархал: Уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд гүн туслалцаа үзүүлсэн УХТЭ-ийн уламжлалтын тасгийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Дарам манрамба Лувсанчойдаг. Алтан хадмал. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо*
2. *Хөх биндэръяа*
3. *Анагаах Ухааны Дөрвөн Үндэс*
4. *Увдисын үндэсний тайлбар сайн номлолт алтанчимэг*
5. *Б.Дагвацэрэн, Н.Төмөрбаатар, Ө.Батчимэг "Өвчнөөс сэргийлэх, оношлох уламжлалт анагаах ухааны үндсэн зарчмын логик, арга зүйн судалгаа" Улаанбаатар, 2003. Анагаах ухааны доктор (Ph.D.)-ын зэрэг горилж бичсэн диссертаци*
6. *Л.Үнэнцацрал "Монгол эмэгтэйн цэвэршилтийн үе, нөлөөлөх хүчин зүйл" УБ, 2008. Анагаах ухааны магистрийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл.*
7. *Я.Ганбаяр, Н.Төмөрбаатар "Монголын уламжлалт анагаах ухааны онолын үндэс" Улаанбаатар. 2003.*
8. *С.Сээрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг, П.Молор-Эрдэнэ, "Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увдис" Улаанбаатар, 2012.*

Research work to determine the characteristics of physical changes in menopausal women

Kh.Purevjav[1],J.Enkhtsetseg[1], Z.Bolortulga[1], A.Ankhzaya[2], G. Erdenechimeg[2]

[1]Mongolian National University of Medical Sciences
[2]The second general hospinal,Tradional department
Email: chimgee6707@gmail.com

Abstract: In the literature “Golden subtitle”, there are two types of summary and show details in distinguishing the nature of the body. The specificity of the body is divided into seven categories: three of wind, bile, and phlegm and three of combined wind and bile, combined phlegm and bile and combined phlegm and bile and one of all three gathered. In this study we aimed to determine characteristics of physical changes in menopausal women and to identify characteristics of women's physical changes in the menopausal age category. The result of research were 28.7% of the total 21 women’s nature of the body have most of the wind and combined phlegm. And 19% of the women’s nature of the body have combined bile. And 19% of the women’s nature of the body have most of the wind and bile combined. And 9,5% of the women’s nature of the body have most bile and combined phlegm. And 4,8% of the women’s nature of the body have most phlegm and combined wind.

Keywords: Mongolian medicine